



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

399.	Гаалийн тарифын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Дугаар 306	1485
400.	Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 307	1493
401.	Ой тэмдэглэх тухай	Дугаар 320	1498
402.	Зарим чиг үүргийг шилжүүлэх тухай	Дугаар 323	1499

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 9 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 306

Улаанбаатар
хот

Гаалийн тарифын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 6.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гаалийн тарифын зөвлөлийн дүрмийг 1 дүгээр, Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Гаалийн тарифтай холбоотой бодлогын асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийн өмнө Гаалийн тарифын зөвлөлөөр хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

3. Гаалийн тарифын зөвлөлийн 2014 оны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Эдийн засгийн хөгжлийн сайдын 2014 оны төсвийн багцаас, 2015 оноос эхлэн холбогдох зардлыг улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Гаалийн тарифын зөвлөлийн дүрэм батлах тухай” Засгийн газрын 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 91 дүгээр тогтоол, “Засгийн газрын комисс, хороо, үндэсний



зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ЭДИЙН ЗАСГИЙН
ХӨГЖЛИЙН САЙД**

Н.БАТБАЯР

Засгийн газрын 2014 оны 306 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ГААЛИЙН ТАРИФЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Гаалийн тарифын зөвлөлийн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтын зарчмыг тодорхойлж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад оршино.

1.2. Гаалийн тарифын зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) хууль дээдлэх, хараат бус, тооцоо судалгаанд тулгуурлан шийдвэр гаргах үндсэн зарчмыг баримтална.

1.3. Зөвлөл үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, холбогдох бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.4. Зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, Зөвлөлийн даргын байгууллагын албан тамгыг хэрэглэнэ.

Хоёр. Зөвлөлийн чиг үүрэг

2.1. Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Монгол Улсын эдийн засгийн ашиг сонирхол, дотоодын зах зээл, үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор гаалийн татвар, тарифын зохистой тогтолцоог бүрдүүлэх, гаалийн татварын хувь, хэмжээг оновчтой тогтоох чиглэлээр судалгаа хийх, дүгнэлт, санал гаргах;

2.1.2. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болон худалдааны нэн тааламжтай тариф (хөнгөлөлттэй тариф) хэрэглэх



хэлэлцээр байгуулсан улсын гарал үүсэлтэй бараа, бүтээгдэхүүнд тарифын нэн тааламжтай нөхцөл олгох, хөгжингүй орнуудаас үзүүлдэг тарифын хөнгөлөлтийг ашиглах талаар тарифын хэлэлцээ хийх санал боловсруулах;

2.1.3. худалдааны аль нэг түнш орон Монгол Улстай явуулж байгаа худалдааны харилцаанд Дэлхийн худалдааны байгууллагын зарчим, хэм хэмжээнд харшилсан бодлого явуулж, урьдчилан зөвшилцөхгүйгээр дангаараа худалдааны нөхцөлийг дордуулсан тариф болон тарифын бус арга хэмжээг авч хэрэгжүүлсний эсрэг авах хариу арга хэмжээний талаар санал боловсруулах.

Гурав. Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

3.1. Зөвлөл нь 15 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд төсөв, худалдаа, гадаад харилцаа, гааль, татвар, эрчим хүч, уул уурхай, зам, тээвэр, үйлдвэр, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

3.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

3.3. Зөвлөлийн дарга нь төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Зөвлөлийн орлогч дарга нь худалдааны асуудал эрхэлсэн дэд сайд, Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орон тооны ажилтан байна.

3.4. Зөвлөлийн гишүүнийг дараах үндэслэлээр Засгийн газар чөлөөлж болно:

3.4.1. биеийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан зөвлөлийн гишүүний үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

3.4.2. үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн;

3.4.3. төлөөллөө хэрэгжүүлэх чадамжгүй болсон;

3.4.4. гэмт хэрэг үйлдсэнийг нь тогтоосон шүүхийн тогтоол хүчин төгөлдөр болсон;

3.4.5. ашиг сонирхлын зөрчил үүссэн гэдэг нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;



3.4.6. зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлсэн байгууллага өөрчлөх, эгүүлэн татах хүсэлт гаргасан.

3.5. Зөвлөлийн гишүүн дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

3.5.1. гаалийн тарифтай холбоотой өөрийн салбарын бодлогын асуудлыг тооцоо судалгаатай боловсруулж, гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан санал, зөвлөлийн хурлын шийдвэрийн төсөл, холбогдох бусад материалын хамт зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, санал гаргах;

3.5.2. зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хариуцан ажиллаж, ажлын гүйцэтгэл, үр дүн болон холбогдох бусад асуудлын талаар зөвлөлийн хуралд мэдээлэл хийх;

3.5.3. зөвлөлийн хуралдаанд таслах эрхтэй оролцох;

3.5.4. зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, шийдвэрийн үр дүн, нөлөөллийн талаар судалгаа хийх;

3.5.5. зөвлөлийн нарийн бичгийн даргад зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх.

3.6. Зөвлөлийн дарга энэхүү дүрмийн 3.5-д зааснаас гадна дараах бүрэн эрхтэй:

3.6.1. зөвлөлийн хуралдааныг товлох, удирдан явуулах;

3.6.2. зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалт батлах;

3.6.3. зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас судалгаа, баримт материал гаргуулан авах.

3.7. Зөвлөлийн даргын түр эзгүйд түүний үүргийг зөвлөлийн орлогч дарга гүйцэтгэнэ.

3.8. Зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах чиг үүрэгтэй:

3.8.1. зөвлөлийн хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангах;



3.8.2. зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтлөх, архив бүрдүүлэх;

3.8.3. зөвлөлийн гишүүнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.8.4. зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, зөвлөлийн дарга, орлогч даргыг холбогдох мэдээллээр хангах;

3.8.5. зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэхээр зөвлөлийн гишүүнээс ирүүлсэн санал, холбогдох тооцоо судалгааг хянан үзэх, шаардлагатай тохиолдолд баримт бичгийн бүрдэл хангуулахаар буцаах;

3.8.6. зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах;

3.8.7. энэхүү дүрмийн 2.1-д заасан чиг үүргийн хүрээнд судалгаа хийх, зөвлөлийн дарга, орлогч даргад танилцуулах.

3.9. Зөвлөлийн нарийн бичгийн даргыг худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

3.10. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанаас дүгнэлт, санал гаргана.

Дөрөв. Зөвлөлийн хуралдааны дэг

4.1. Зөвлөл улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.

4.2. Хуралдааны товыг хуралдаан болохоос ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох баримт бичгийг хүргүүлсэн байна.

4.3. Баримт бичгийн бүрдэл хангаагүй асуудлыг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэхгүй.

4.4. Зөвлөлийн хуралдаанд Зөвлөлийн гишүүн 1 саналын эрхтэй. Зөвлөлийн нарийн бичгийн дарга саналын эрхгүй.

4.5. Хуралдаан нийт гишүүдийн гуравны хоёроос цөөнгүй нь оролцсоноор хүчин төгөлдөр болно.



4.6. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд биеэр оролцох боломжгүй гишүүн хуралдаан эхлэхээс өмнө саналаа бичгээр хүргүүлж болно. Энэ тохиолдолд түүнийг хуралдаанд оролцсонд тооцно.

4.7. Хуралдаанд зөвлөлийн нарийн бичгийн дарга заавал оролцох бөгөөд хэлэлцэгдэж байгаа асуудалтай холбогдох бусад этгээдийг оролцуулж болно.

4.8. Хуралдааныг нээлттэй явуулна.

Тав. Зөвлөлийн санал, дүгнэлт гаргах

5.1. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын танилцуулгыг тухайн асуудлыг оруулж байгаа зөвлөлийн гишүүн хийнэ.

5.2. Гишүүд болон бусад холбогдох оролцогч танилцуулсан асуудлаар саналаа хэлнэ.

5.3. Хуралдаан даргалагч хэлэлцэж байгаа асуудлын талаар гарсан саналыг нэгтгэж, санал, дүгнэлтийн төслийг танилцуулна.

5.4. Санал, дүгнэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналыг үндэслэн гаргана. Гишүүдийн саналыг илээр хураана.

5.5. Санал, дүгнэлт гаргахад Монгол Улсын олон улсын гэрээ, Дэлхийн худалдааны байгууллагын зарчим, хэм хэмжээ, Дэлхийн худалдааны байгууллагад элсэн орохдоо хүлээсэн манай улсын үүрэг, амлалт, түүнчлэн дотоодын зах зээл, үйлдвэрлэлд үзүүлэх нөлөө, ач холбогдлыг харгалзан үзнэ.

5.6. Санал, дүгнэлтэд хуралдаан даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

5.7. Санал, дүгнэлтийг тухайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

5.8. Хуралдааны тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлж, ажлын 5 өдөрт багтаан албажуулна. Тэмдэглэлд хуралдаанаар хэлэлцсэн асуудлын жагсаалт, гишүүдийн ирц, хуралдааны явц, хуралдаанд оролцогчдын хэлсэн үг, гаргасан саналыг дэлгэрэнгүй үнэн зөв, бүрэн гүйцэд тусгасан байна.



5.9. Хуралдааны тэмдэглэлд зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулна.

Зургаа. Зөвлөлөөс бусад байгууллагатай харилцах

6.1. Зөвлөл нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана. Шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал боловсруулах, судалгаа хийх зорилгоор ажлын хэсэг, шинжээч, зөвлөх ажиллуулж болно.

6.2. Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гаалийн тарифтай холбоотой бодлогын асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийн өмнө Зөвлөлийн саналыг албан ёсоор авсан байна.

6.3. Салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага гаалийн тарифтай холбоотой бодлогын асуудлыг тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан тус байгууллагыг төлөөлсөн зөвлөлийн гишүүнээр уламжлан зөвлөлд оруулж хэлэлцүүлж болно.

6.4. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаад худалдааны статистик мэдээллийг сар бүрийн эхний 14 хоногийн дотор албан ёсоор зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

Долоо. Бусад

7.1. Зөвлөлийн ажиллах нөхцөлийг хангах, судалгаа хийх, үйл ажиллагаатай нь холбогдон гарах бусад зардлыг худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсөвт тусган санхүүжүүлнэ.

7.2. Зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүнд тэдгээрийн хуралд оролцсон байдлыг харгалзан урамшуулал олгож болох бөгөөд түүний хэмжээ, олгох журмыг худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.3. Зөвлөл нь Засгийн газарт хагас жил тутам үйл ажиллагаагаа тайлагнана.



Засгийн газрын 2014 оны 306 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ГААЛИЙН ТАРИФЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Сангийн сайд
Орлогч дарга	-Эдийн засгийн хөгжлийн дэд сайд
Гишүүд:	-Гаалийн ерөнхий газрын дарга; -Татварын ерөнхий газрын дарга; -Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал; -Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга; -Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Зам, тээврийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга; -Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга; -Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга; -Эрчим хүчний яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга; -Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Эдийн засгийн хөгжлийн яамны Худалдааны хэлтсийн дарга; -Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцсоноор); -Монгол Улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн захирал (тохиролцсоноор).
Нарийн бичгийн дарга	-Эдийн засгийн хөгжлийн яамны ажилтан (орон тооны).



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 9 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 307

Улаанбаатар
хот

Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 16.2, 21.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ойгоос хэрэглээний мод бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг 1 дүгээр, Ойгоос түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг 2 дугаар, Иргэн, аж ахуйн нэгж байгууллага ойн арчилгаа, цэвэрлэгээний аргаар түлшний мод бэлтгэж ашигласны төлбөрийг хөнгөлөх хувь, хэмжээг 3 дугаар хавсралт ёсоор тогтоосугай.

2. Тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Сангийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2005 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 147 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖЛИЙН САЙД**

С.ОЮУН

Засгийн газрын 2014 оны 307 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ОЙГООС ХЭРЭГЛЭЭНИЙ МОД БЭЛТГЭЖ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Модны төрөл	Мод тээврийн зай 50 км хүртэл						Мод тээврийн зай 50 км –ээс дээш байхад									
		Үйлдвэрлэлийн огтлолт		Арчилгааны огтлолт		Цэвэрлэгээний огтлолт		Ойн цэвэрлэгээний ажил		Үйлдвэрлэлийн огтлолт		Арчилгааны огтлолт		Цэвэрлэгээний огтлолт		Ойн цэвэрлэгээний ажил	
		Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг
Нэгдүгээр муж																	
1	Гацуур	12	36720	10	30600	30	18000	25	15000	10	30600	8.5	26010	25	15000	20	12000
2	Нарс	12	30600	10	25500	30	18000	25	15000	10	25500	8.5	21675	25	15000	20	12000
3	Шинэс	12	24480	10	20400	30	18000	25	15000	10	20400	8.5	17340	25	15000	20	12000
4	Хус	12	14400	10	12000	15	9000	12	7200	10	12000	8.5	10200	12	7200	10	6000
5	Улиас, улиангар	12	12240	10	10200	15	9000	12	7200	10	12000	8.5	8670	12	7200	10	6000
6	Бургас	12	10800	10	9000	15	9000	12	7200	10	12000	8.5	7650	12	7200	10	6000
Хоёрдугаар муж																	
1	Гацуур	12	24120	10	20100	30	11700	25	9750	10	20100	8.5	17085	25	9750	20	7800
2	Нарс	12	19800	10	16500	30	11700	25	9750	10	16500	8.5	14025	25	9750	20	7800

3	Шинэс	12	15840	10	13200	30	11700	25	9750	10	13200	8.5	11220	25	9750	20	7800
4	Хус	12	9360	10	7800	15	5850	12	4680	10	7800	8.5	6630	12	4680	10	3900
5	Улиас, улиангар	12	7920	10	6600	15	5850	12	4680	10	6600	8.5	5610	12	4680	10	3900
6	Бургас	12	7200	10	6000	15	5850	12	4680	10	6000	8.5	5100	12	4680	10	3900
Гуравдугаар муж																	
1	Гацуур	12	17280	10	14400	30	8550	25	7125	10	14400	8.5	12240	25	7125	20	5700
2	Нарс	12	14400	10	12000	30	8550	25	7125	10	12000	8.5	10200	25	7125	20	5700
3	Шинэс	12	11520	10	9600	30	8550	25	7125	10	9600	8.5	8160	25	7125	20	5700
4	Хус	12	6840	10	5700	15	4275	12	3420	10	5700	8.5	4845	12	3420	10	2850
5	Улиас, улиангар	12	5760	10	4800	15	4275	12	3420	10	4800	8.5	4080	12	3420	10	2850
6	Бургас	12	5040	10	4200	15	4275	12	3420	10	4200	8.5	3570	12	3420	10	2850

Тайлбар:

- 1.*Ойн экологи-эдийн засгийн үнэлгээнээс тооцсон хувь
2. Үйлдвэрлэл, арчилгаа, цэвэрлэгээний огтлолтоос гарах хэрэглээний модны төлбөрийн хэмжээг том хэмжээний хэрэглээний модонд тооцсон бөгөөд дунд хэмжээний хэрэглээний модонд төлбөрийн хэмжээнээс 15 хувиар, жижиг хэмжээний хэрэглээний модонд төлбөрийн хэмжээнээс 30 хувиар бууруулж тооцно.



3. Бэлтгэсэн модны нарийн үзүүрийн голч нь 25.0 см-ээс дээш бол том, 13.0-24.9 см бол дунд, 2.5-12.9 см бол жижиг хэмжээний хэрэглээний модонд тус тус тооцно.

Засгийн газрын 2014 оны 307 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ОЙГОС ТҮЛЭЭ БЭЛТГЭЖ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Модны төрөл	Мод тээврийн зай 50 км хүртэл						Мод тээврийн зай 50 км –ээс дээш байхад											
		Үйлдвэрлэлийн огтлолт		Арчилгааны огтлолт		Цэвэрлэгээний огтлолт		Ойны цэвэрлэгээний ажил		Үйлдвэрлэлийн огтлолт		Арчилгааны огтлолт		Цэвэрлэгээний огтлолт		Ойны цэвэрлэгээний ажил			
		Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг	Хувь*	Төгрөг		
1	Гашуур	2	6120	2	6120	10	6000	10	6000	2	6120	2	6120	2	6120	6	3600	6	3600
2	Нарс	2	5100	2	5100	8	4800	8	4800	2	5100	2	5100	2	5100	4	2400	4	2400
3	Шинэс	2	4080	2	4080	6	3600	6	3600	2	4080	2	4080	2	4080	4	2400	4	2400
4	Хус	3	3600	3	3600	4	2400	4	2400	2	2400	2	2400	2	2400	3	1800	3	1800
5	Улиас, улиангар	3	2040	3	2040	4	2400	4	2400	2	2040	2	2040	2	2040	3	1800	3	1800
6	Бургас	2	3060	2	3060	4	2400	4	2400	2	1800	2	1800	2	1800	3	1800	3	1800
7	Зар	-	-	-	-	-	-	10	9000	-	-	-	-	-	-	-	-	8	7200

Нэгдүгээр муж

Бусад мод бут сөөг (харгана, хармаг, буйлс гэх мэт)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	3	2430		
Хоёрдугаар муж																						
1 Гацуур	2	4020	2	4020	8	3120	8	3120	2	4020	2	4020	2	4020	2	4020	2	4020	6	2340	6	2340
2 Нарс	2	3300	2	3300	6	2340	6	2340	2	3300	2	3300	2	3300	2	3300	2	3300	4	1560	4	1560
3 Шинэс	2	2640	2	2640	6	2340	6	2340	2	2640	2	2640	2	2640	2	2640	2	2640	4	1560	4	1560
4 Хус	2	1560	2	1560	4	1560	4	1560	2	1560	2	1560	2	1560	2	1560	2	1560	3	1170	3	1170
5 Улиас, улиангар	2	1320	2	1320	4	1560	4	1560	2	1320	2	1320	2	1320	2	1320	2	1320	3	1170	3	1170
6 Бургас	2	1200	2	1200	4	1560	4	1560	2	1200	2	1200	2	1200	2	1200	2	1200	3	1170	3	1170
Гуравдугаар муж																						
1 Гацуур	3	4320	4320	4320	10	2850	10	2850	2	2880	2	2880	2	2880	2	2880	2	2880	6	1710	6	1710
2 Нарс	3	3600	3600	3600	8	2280	8	2280	2	2400	2	2400	2	2400	2	2400	2	2400	4	1140	4	1140
3 Шинэс	3	2880	2880	2880	8	2280	8	2280	2	1920	2	1920	2	1920	2	1920	2	1920	4	1140	4	1140
4 Хус	3	1710	1710	1710	5	1425	5	1425	2	1140	2	1140	2	1140	2	1140	2	1140	2	570	2	570
5 Улиас, улиангар	3	1440	1440	1440	4	1140	4	1140	2	960	2	960	2	960	2	960	2	960	2	570	2	570
6 Бургас	3	1260	1260	1260	4	1140	4	1140	2	840	2	840	2	840	2	840	2	840	2	570	2	570

Тайлбар: 1.*-Ойн экологи-эдийн засгийн үнэлгээнээс тооцсон хувь



Засгийн газрын 2014 оны 307 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА ОЙН АРЧИЛГАА
ХИЙХ БОЛОН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АРГААР ТҮЛШНИЙ
МОД БЭЛТГЭЖ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙГ
ХӨНГӨЛӨХ ХУВЬ, ХЭМЖЭЭ

д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Түлшний мод бэлтгэхэд хөнгөлөх хувь, хэмжээ	Арчилгааны огтлолт явуулахад хөнгөлөх хувь, хэмжээ	
1	Цэвэрлэгээний аргаар хожуул, унангийг түлээнд зориулан бэлтгэх	а) шилмүүст мод	хувь	30	-
		б) навчит мод	хувь	20	-
2	Цэвэрлэгээний аргаар үзүүр, мөчир, гишүүг ойгоос түүж бэлтгэх	хувь	50	-	
3	Ойд гэрэлжүүлэх, тохируулах арчилгааны огтлолт хийх	хувь	-	100	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 10 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 320

Улаанбаатар
хот

**Ой тэмдэглэх
тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын гавьяат багш, академич Дондогийн Цэвэгмидийн мэндэлсний 100 жилийн ойг 2015 онд тэмдэглэсүгэй.



2. Ойг тэмдэглэх ажлын хүрээнд Д.Цэвэгмидийн амьдрал, уран бүтээлийн түүхэн замналаар эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн зохион байгуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ГАНТӨМӨР

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Ц.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 10 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 323

Улаанбаатар
хот

Зарим чиг үүргийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний “Газрын шинэтгэлийн хороо”, “Усны үндэсний хороо”-ны ажлын албадыг татан буулгаж, тэдгээрийн чиг үүргийг Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд шилжүүлсүгэй.

2. Чиг үүрэг шилжүүлсэнтэй холбоотойгоор холбогдох зардлыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны 2015 оны төсөвт тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.



3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Орон тооны ажлын албадын тухай” Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 117 дугаар тогтоолын 4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 14003